

ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар

Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн холбогдох зохицуулалтын тайлбарыг гаргав. Үүнд:

1.Нэмэлт, өөрчлөлт оруулах, өөрчлөн найруулах, үг өгүүлбэрийг хасах, хүчингүй болсонд тооцох болсон үндэслэл, шаардлага

Нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн зүйл, хэсэг	Үндэслэл, шаардлага
1 дүгээр зүйл буюу хуульд доор дурдсан агуулгатай дараах зүйл, хэсэг, заалт нэмэх болсон үндэслэл, шаардлагын талаар	
<p>1/51 дүгээр зүйлийн 51.3 дахь хэсэг:</p> <p>“51.3.Нэхэмжлэхийг хүлээн авсан татвар төлөгч хүндэтгэн үзэх шалтгаан бүхий хүсэлтээ татварын албанд хүргүүлсэн тохиолдолд энэ хуулийн 51.1.7-д заасан хугацааг нэг удаа ажлын 7 хүртэл өдрөөр сунгаж болно.”</p>	<p>Төслийн тайлбар: Татвар төлөгч дараах хүндэтгэн үзэх шалтгаантайгаа нотолсон бол нэхэмжлэхийн дагуу татварын өр төлөх хугацааг ажлын 7 хүртэл хоногоор сунгаж болох зохицуулалтыг нэмэв.</p> <p>6.1.41."хүндэтгэн үзэх шалтгаан" гэж:</p> <p>6.1.41.а.эмнэлгийн өвчтөний гар картад бичигдсэн бөгөөд лаборатори болон багажийн шинжилгээгээр эмчлүүлэх шаардлагатай нь нотлогдож, эмч, эмнэлгийн байгууллагын гаргасан магадлагаагаар эмнэлэгт хэвтэн эмчлүүлж байгаа;</p> <p>6.1.41.б.эмч, эмнэлгийн байгууллагын гаргасан магадлагаагаар энэ хуулийн 6.1.41.а-д заасны дагуу эмнэлэгт хэвтэн эмчлүүлж байгаа өвчтөнийг асарсан;</p> <p>6.1.41.в.хуульд заасан эрх бүхий этгээдийн зарласан нийтийг хамарсан дайчилгаанд хамрагдсан;</p> <p>6.1.41.г.хуульд заасан эрх бүхий этгээдийн зарласан нийтийг хамарсан аюулт халдварт өвчний улмаас хорио цээр тогтоосон бүсэд хоригдсон;</p> <p>6.1.41.д.хуульд заасан эрх бүхий этгээдээс албан ёсоор зарласныг нотолсон галын болон байгалийн гэнэтийн аюул, эсхүл давагдашгүй хүчин зүйл /усны үер, ган, зуд, аюултай цасан болон шороон шуурга, газар хөдлөлт/ зэрэг шалтгааныг;</p>

	<p><i>Татварын ерөнхий хуулийн 51.1.7-д “нэхэмжлэхийг татвар төлөгчид хүргүүлснээс хойш ажлын 10 хүртэл өдөрт багтаан татварын өрийг төлөх тухай шаардлага;” гэж заасан бөгөөд нэхэмжлэхийг хүлээн авсан татвар төлөгч уг хугацаанд багтаан хүсэлтээ гаргах боломжтой байхаар заав. Уг хугацаа дууссанаар татварын өрийг үл маргах журмаар гаргуулах процесс эхэлнэ.</i></p>
<p>2/63 дугаар зүйлийн 63.2 дахь хэсэг:</p> <p>“63.2.Дансыг битүүмжилсэн хугацаанд тухайн дансанд орлогын гүйлгээ хийх, цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлийг шүүхийн зөвшөөрлөөр бүрэн, эсхүл хэсэгчлэн төлөх боломжтой байна.”</p>	<p>Төслийн тайлбар: Татварын ерөнхий хуульд өртэй татвар төлөгчийн дансыг битүүмжлэх тохиолдолд орлогын гүйлгээг зогсоох тухай зохицуулаагүй ч хуулийн хэрэглээг ойлгомжтой болгох үүднээс <u>орлогын гүйлгээгүй зогсоохгүй гэсэн нөхцлийг нэмэв. Мөн ажилтны цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн гүйлгээг шүүхийн зөвшөөрлөөр бүрэн, эсхүл хэсэгчлэн хийх боломжтой байх зохицуулалтыг шинээр нэмэв.</u></p>
<p align="center">2 дугаар зүйл буюу хуулийн дараах зүйл, хэсэг, заалтыг өөрчлөн найруулах үндэслэл, шаардлагын талаар</p>	
<p>1/“51.1.7.нэхэмжлэхийг татвар төлөгчид хүргүүлснээс хойш ажлын 30 хүртэл өдөрт багтаан татварын өрийг хуваан төлөх хуваарьт шаардлага;”</p>	<p>Төслийн тайлбар: Одоогийн хуульд 51.1.7.“нэхэмжлэхийг татвар төлөгчид хүргүүлснээс хойш ажлын 10 хүртэл өдөрт багтаан татварын өрийг төлөх тухай шаардлага;” гэж байгаа бөгөөд хугацааг ажлын 20 өдрөөр нэмэгдүүлэх, түүнчлэн тодорхой графикийн дагуу хэсэгчлэн буюу хуваан төлөх боломжийг бүрдүүлэх үүднээс хуваарьт шаардлага хүргүүлэх нөхцлийг нэмсэн.</p>
<p>2/“63.1.1.татварын улсын байцаагч татварын өрийг өртэй татвар төлөгчийн банкн дахь мөнгөн хөрөнгөөс хураах тухай хүсэлтийг татварын албаны даргаар батлуулан харьяалах шүүхэд гаргах;</p>	<p>Төслийн тайлбар: Одоогийн хуульд “63.1.1.татварын улсын байцаагч татварын өрийг өртэй татвар төлөгчийн банкн дахь мөнгөн хөрөнгөөс хураах тухай битүүмжлэх мэдэгдэх хуудсыг татварын албаны даргаар батлуулан харилцагч банканд хүргүүлэх;” гэж байгаа бөгөөд битүүмжлэх мэдэгдэх хуудсыг банканд шууд хүргүүлэхгүйгээр холбогдох хүсэлтийг шүүхэд гаргахаар өөрчлөн найруулав.</p>
<p>63.1.2.энэ хуулийн 63.1.1-д заасан хүсэлтэд өртэй татвар төлөгчийн нэр, татвар төлөгчийн дугаар, битүүмжилсэн мөнгөн хөрөнгийг шилжүүлбэл зохих банкны нэр, дансны дугаар, харилцагч банкны нэр, хаяг, татварын өр хураах үндэслэл,</p>	<p>Төслийн тайлбар: Одоогийн хуульд “63.1.2.энэ хуулийн 63.1.1-д заасан битүүмжлэх мэдэгдэх хуудсанд өртэй татвар төлөгчийн нэр, татвар төлөгчийн дугаар, битүүмжилсэн мөнгөн хөрөнгийг шилжүүлбэл зохих банкны нэр, дансны дугаар, харилцагч банкны нэр, хаяг, татварын өр хураах үндэслэл, татварын өрийн дүн, зарлагын гүйлгээг бүрэн буюу хэсэгчлэн зогсоох тухай</p>

<p>татварын өрийн дүн, зарлагын гүйлгээг бүрэн, эсхүл хэсэгчлэн зогсоох хугацааны тухай дурдах;</p>	<p>заах;" гэж байгаа бөгөөд шүүхэд гаргах хүсэлтэд зарлагын гүйлгээг бүрэн, эсхүл хэсэгчлэн зогсоох хугацааг мөнхүү тодорхой дурдаж байхаар тусгав.</p>
<p>63.1.3.шүүх энэ хуулийн 63.1.2-т заасан хүсэлтийг ажлын 3 өдрийн дотор хянаж, үндэслэлтэй гэж үзвэл татварын өрийн хэмжээнд багтаан дансны зарлагын гүйлгээг бүрэн буюу хэсэгчлэн зогсоох тухай шийдвэр гаргах;</p>	<p>Төслийн тайлбар: Татварын ерөнхий хуульд тайланг хянаж мэдээллийн зөрүү илэрвэл илрүүлснээс хойш ажлын 3 өдрийн дотор мэдээллийн зөрүүг залруулах шаардлагыг татвар төлөгчид хүргүүлэх, татвар төлөгч шаардлагыг хүлээн авснаас хойш ажлын 3 өдөрт багтаан шаардлагад заасан зөрүүг арилгаж, залруулсан тайланг тушаах, эрсдэлтэй татварыг ажлын 3 өдөрт багтаан төлүүлэхээр урьдчилан нэхэмжлэх хуудас хүргүүлэх, цалин хөлсийг олгох өдөр төлбөрийн хуваарийн дагуу татварын өрийг суутгаж, суутгал хийснээс хойш ажлын 3 өдрийн дотор битүүмжлэх мэдэгдэх хуудсанд заасан дансанд шилжүүлэх зэрэг хугацаа заасан зохицуулалттай дүйцүүлж ажлын 3 өдрийн хугацаанд хянахаар заав.</p>
<p>63.1.4.татварын улсын байцаагч шүүхийн шийдвэрт заасан хязгаарын хүрээнд битүүмжлэх мэдэгдэх хуудсыг үйлдэж өртэй татвар төлөгчийн харилцагч банканд хүргүүлэх;</p> <p>63.1.5.шүүхийн шийдвэрээр баталгаажсан битүүмжлэх мэдэгдэх хуудас хүлээн авсан даруйд банк тухайн дансны зарлагын гүйлгээг битүүмжлэх мэдэгдэх хуудаст заасан хэмжээгээр бүрэн буюу хэсэгчлэн зогсоох;</p> <p>63.1.6.банк татварын албаны шийдвэрийн үндсэн дээр битүүмжлэх мэдэгдэх хуудсанд заасан дансанд өртэй татвар төлөгчийн нэг буюу түүнээс дээш дансанд байгаа битүүмжилсэн мөнгөн хөрөнгөөс татварын өрийг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн шилжүүлэх;"</p>	<p>Төслийн тайлбар: Одоогийн хуульд "63.1.3.битүүмжлэх мэдэгдэх хуудас хүлээн авсан даруйд банк битүүмжлэх мэдэгдэх хуудсанд заасан дансанд өртэй татвар төлөгчийн нэг буюу түүнээс дээш дансанд байгаа мөнгөн хөрөнгөөс татварын өрийг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн шилжүүлэх;" гэсэн ба банк мэдэгдэх хуудас авсан даруйд мөнгөн хөрөнгөөс шилжүүлэхээр заасан. Төслийн зохицуулалтаар шүүхийн шийдвэрээр баталгаажсан мэдэгдэх хуудсыг хүлээн авсан банк зөвхөн дансны зарлагыг гүйлгээг зогсоох ба үүний дараа татварын албаны шийдвэрийг авсны дараа мөнгөн хөрөнгөөс шилжүүлэхээр заасан.</p>

<p>3 дугаар зүйл.Татварын ерөнхий хуулийн 63.1.4 дэх заалтын дугаарыг “63.1.7” гэж тус тус өөрчилсүгэй.</p>	<p>Төслийн тайлбар: Заалт нэмсэнтэй холбоотойгоор дугаарыг шилжүүлэхээр тусгасан.</p>
<p>4 дүгээр зүйл буюу хүчингүй болгох зүйл, хэсэг, заалтын талаар</p>	
<p>4 дүгээр зүйл. Татварын ерөнхий хуулийн 47 дугаар зүйлийн 47.3, 47.4 дэх хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.</p>	<p>Төслийн тайлбар: Татварын нөхөн ногдуулалтын актад гомдол гаргахдаа маргаантай байгаа татварын дүнгийн тодорхой хувийг урьдчилж төлдөг зохицуулалтыг халж, иргэдийн шударга шүүхээр хамгаалуулах эрхийг баталгаажуулахаар тусгав.</p>
<p>5 дугаар зүйл буюу хуулийг дагаж мөрдөх журмын талаар</p>	
<p>5 дугаар зүйл.Энэ хуулийг 2027 оны ... дүгээр сарын ...-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.</p>	<p>Төслийн тайлбар: Энэхүү хуулийн төслийг 2027 оноос эхлэн дагаж мөрдөхөөр боловсруулав.</p>

2.Зохицуулахаар тусгасан харилцааны агуулга, зохицуулалт нь Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалд тусгагдсан бөгөөд үзэл баримтлалын хүрээнээс гажаагүй болно.

3.Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд шинэ нэр томъёо, ухагдахуун оруулаагүй бөгөөд Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томъёог хэрэглэж уг хуулийн төслийг боловсруулсан болно.

ХУУЛЬ САНААЧЛАГЧ

--oOo--